



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/164

Улаанбаатар хот


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2014 оны 279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.9.5, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шарилжгүй Улаанбаатар-4” аяны хүрээнд ажиллах иргэдийн бүлгийн ажилчдад нэмэлтээр автомат хадуур худалдан авах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Төхижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

2. Хөл газрын ургамлыг тайрч, цэвэрлэхэд зориулсан 10 ширхэг автомат хадуур худалдан авахад шаардагдах зардлын тооцоог хавсралт ёсоор баталсугай.

3. Автомат хадуур худалдан авахад шаардагдах 2,500,000 /Хоёр сая таван зуун мянган/ төгрөгийг Ногоон байгууламжийн арчилгааны зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

